

ҮНДЭСЛЭЛ:

Монгол улс нь уламжлалт анагаах ухааны онол, аргазүйн арвин өв сантай билээ. Улс орон бүр өөрсдийн уламжлалт анагаах ухааны өв соёлтой бөгөөд 5000 жилийн түүхтэй монголын уламжлалт анагаах ухааны хөгжил 1990-ээд оноос эрчимжиж иржээ.

Сүүлийн жилүүдэд уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүд батлагдан гарсан байна. Тухайлбал:

Монгол улс 1999 онд “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ыг Улсын Их Хурлаар батласан нь нийтлэг үндэслэл, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх төрийн бодлогын үндсэн чиглэл гэсэн 2 бүлэг, 19 заалттай бөгөөд манай орныг ДЭМБ-ын гишүүн 192 орноос УАУ-ны талаар төрийн бодлоготой 25 орны нэг бөгөөд УАУ-ны нэгдмэл тогтолцоотой улс орон болгосон нэн чухал ач холбогдолтой түүхэн баримт бичиг юм.

2015 он хүртэл баримтлах үйл ажиллагааны чиглэлүүдийг тодорхойлсон тус хуульд тухайн цаг хугацаанд хүрсэн түвшин, бий болсон материаллаг бааз, хүний нөөцийн хангамж зэргийг үнэлэн цэгнэхийн хамт цаашид улсын хэмжээнд уламжлалт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй, чанартай найдвартай үзүүлдэг болгох үүднээс төрөөс баримтлах чиглэлүүд тодорхойлогдсон.

Монгол улсын эрүүл мэндийн салбар, ер нь дэлхий дахинд хүн төрөлхтний сайн сайхны тулд эрт дээр үеэс хэрэглэж ирсэн уламжлалт анагаахын оношлогоо, эмчилгээний арга, эм тангийн талаар улам гүнзгий, өргөн цар хүрээтэй, илүү үр ашигтай бүтээлч судалгаа хийх хэрэгтэй гэж үзсээр байна.

Зорилго: Монголын уламжлалт анагаах ухааны судалгааны өнөөгийн байдлыг судалж, Монголын уламжлалт анагаах ухааны судалгааг хөгжүүлэх чиглэлээр зарим мэдээллийг бий болгох зорилготой.

Судалгааны зорилтууд:

- 1) Сүүлийн 10 жилд УАУ-ны чиглэлээр дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүл болон цахим хуудсанд нийтлэгдсэн судалгааны ажлыг шүүж нэгтгэн голлон хийгдэж буй судалгааны чиглэлүүдийг гаргах
- 2) УАУ-ны чиглэлээр нийтлэгдсэн судалгааны ажлын чанарт эксперт томилон дүн шинжилгээ хийх

Хүлээгдэж буй үр дүн: Уламжлалт анагаах ухааны судалгааны өнөөгийн байдлын талаарх мэдээлэл бий болно

Судалгааны материал, аргазүй

Баримтын судалгаанд ашигласан материал: Сүүлийн 10 жилийн туршид уламжлалт анагаахын чиглэлээр дотоод, гадаадын сэтгүүл болон цахим хуудсанд нийтлэгдсэн судалгааны бүх мэдээлэл

Судалгааны загвар, аргазүй: Уламжлалт анагаах ухааны бүтээлийн чанарт үнэлгээ өгөхийн тулд PubMed, MongolMed, Coreamed, WPRIM гэсэн анагаах ухааны эрдэм шинжилгээний сэтгүүлийн цахим мэдээний санд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний, өгүүлэл, илтгэлийг татан авч, ангилан дүн шинжилгээ хийв.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд нийтлэгдсэн уламжлалт анагаах ухааны чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудыг 4 web (www.mongolmed.mn, www.pubmed.gov, www.koreamed.org, www.wprim.org) хуудас, 8 (Mongolian Journal of Health Sciences, Дорно дахины уламжлалт анагаах ухаан,


Монголын анагаах ухаан, Онош, Монголын уламжлалт анагаах ухаан, Эрүүл мэндийн шинжлэх ухаан, Инноваци-шинэ санаа, шинэ нээлт, Халдварт өвчин судлал) анагаах ухааны сэтгүүлийн сүүлийн 10 жилд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийг шүүж нэгтгэв.

Үүнд:

1. Уламжлалт анагаах ухааны эм болон эмийн түүхий эдийн чиглэлээр 101 эрдэм шинжилгээний бүтээл хэвлэгдсэн байна. Үүнээс:
 - Уламжлалт анагаах ухааны эмийн чиглэлээр лабораторийн судалгааны ажил 42
 - Уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эдийн чиглэлээр лабораторийн судалгааны ажил 59
2. Эмнэлзүйн судалгаа 13
3. Уламжлалт анагаах ухааны онол, эх бичгийн судалгаа 23
4. Уламжлалт анагаах ухааны тогтолцооны судалгаа 7

Нийт 145 судалгааны ажил байна.

ДҮРСЛЭЛ 1. ХЭВЛЭГДСЭН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН БҮТЭЦ



Дээрх зургаас харахад нийт эрдэм шинжилгээний бүтээлүүдээс эм болон эмийн түүхий эдийн судалгаа 70% буюу хамгийн их хувийг, харин эмнэлзүйн судалгаа 9%, тогтолцооны судалгаа 5% буюу хамгийн бага хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛҮҮДИЙГ ТОВЧЛОЛ, ӨГҮҮЛЛЭЭР АНГИЛАХАД

№	Судалгааны ажлын хэвлэгдсэн хэлбэр	УАУ-ны эм болон эмийн түүхий эдийн судалгаа	УАУ-ны онол, эх бичиг	Эмнэлзүйн судалгаа	УАУ-ны тогтолцоо	Нийт тоо	хувь
1	Судалгааны хураангуй	23	8	9	1	41	28.5%
2	Судалгааны өгүүлэл	78	15	4	6	103	71.5%
	Нийт	101	23	13	7	144	100%

Нийт эрдэм шинжилгээний бүтээлээс 41 (28.5%) нь товчлол, 103 (71.5%) нь өгүүлэл байна.

ХҮСНЭГТ 2. МОНГОЛ ЭРДЭМТЭН, СУДЛААЧДИЙН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ ЦАХИМ ХУУДСАНД НИЙТЛЭГДСЭН БАЙДАЛ

№	Судалгааны ангилал	www.mongolmed.mn	www.pubmed.gov	www.koreamed.org	www.wprim.org
1	УАУ-ны эмийн лабораторийн судалгаа	8	6	1	1
2	УАУ-ны эмийн түүхий эдийн лабораторийн судалгаа	24			1
3	УАУ-ны эм болон эмийн түүхий эдийн онолын судалгаа	3			1
4	УАУ-ны онол болон эх бичиг	5	2		
5	Эмнэлзүйн судалгаа	12			
6	УАУ-ны тогтолцоо	7			
НИЙТ		59	8	1	3

www.mongolmed.mn-д 59 эрдэм шинжилгээний бүтээл байгаагаас 8 нь уламжлалт анагаах ухааны эмийн, 24 нь эмийн түүхий эдийн, 3 нь эм болон эмийн түүхий эдийн онолын судалгаа байна. Мөн 5 нь уламжлалт анагаах ухааны онолын судалгаа, 12-н эмнэлзүйн судалгаа, 7-н тогтолцооны судалгаа тус тус байна. www.pubmed.gov-д 8 эрдэм шинжилгээний бүтээл байгаагаас 6 нь эмийн, 2 нь онолын судалгаа байна. www.koreamed.org-д эмийн 1 судалгаа, www.wprim.org-д эмийн 1, түүхий эдийн 1, онолын 1 нийт 3 байна.

ХҮСНЭГТ 3. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛҮҮДИЙГ ХЭВЛЭГДСЭН СЭТГҮҮЛЭЭР НЬ АВЧ ҮЗСЭН НЬ

№	Судалгааны ажлын хэвлэгдсэн хэлбэр	УАУ-ны эм болон эмийн түүхий эдийн судалгаа	УАУ-ны онол, эх бичиг	Эмнэлзүйн судалгаа	УАУ-ны тогтолцоо	НИЙТ
1	Mongolian Journal of Health Sciences	7	1	1	1	10
2	Дорно дахины уламжлалт анагаах ухаан	41	5	2	1	49
3	Монголын анагаах ухаан	24	3	7	4	38
4	Онош	4		1	1	6
5	Монголын уламжлалт анагаах ухаан	28		1		29
6	Эрүүл мэндийн шинжлэх ухаан	1				1
7	Инноваци-шинэ санаа, шинэ нээлт	1				1
8	Халдварт өвчин судлал			1		1
Нийт		106	9	13	7	135

Дээрх хүснэгтээс харахад 8 сэтгүүлд 135 судалгааны ажил хэвлэгдсэн байна.

Үүнээс:

- Mongolian Journal of Health Sciences 10
- Дорно дахины уламжлалт анагаах ухаан сэтгүүл 49
- Монголын анагаах ухаан 38
- Онош сэтгүүлд 6
- Монголын уламжлалт анагаах ухаан 29
- Эрүүл мэндийн шинжлэх ухаан, Инноваци-шинэ санаа, шинэ нээлт, Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүлд тус тус 1 судалгааны ажил нийтлэгдсэн байна.

ХҮСНЭГТ 4. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ТОВЧЛОЛД ӨГСӨН ШИНЖЭЭЧДИЙН ҮНЭЛГЭЭ

	эмийн түүхий эд	уламжлалт эм	эмийн онолын судалгаа	эмнэлзүйн судалгаа	онол, эх бичгийн судалгаа	Тогтолцооны судалгаа
Дундаж утга	91.6	89.4	67	61.6	86.3	90
Их утга	100	100	71	88	93	90
Бага утга	58	52	63	34	80	90

Дээрх хүснэгтээс харахад шинжээчдийн Эрдэм шинжилгээний бүтээлийн товчлолд өгсөн үнэлгээгээр эмийн түүхий эдийн судалгаа дунджаар 91.6 оноо, уламжлалт эмийн судалгаа 89.4 оноо, онол, эх бичгийн судалгаа 86.3 оноо, эмийн онолын судалгаа 67 оноо, эмнэлзүйн судалгаа 61.6 оноо авсан байна.

Харин дээрх бүтээлүүдээс эмнэлзүйн судалгаанд хамгийн доогуур үнэлгээ (34 оноо) авсан судалгаа байсан байна.

ХҮСНЭГТ 5. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛД ӨГСӨН ШИНЖЭЭЧДИЙН ҮНЭЛГЭЭ

	эмийн түүхий эд	уламжлалт эм	эмийн онолын судалгаа	эмнэлзүйн судалгаа	онол, эх бичгийн судалгаа	Тогтолцооны судалгаа
Дундаж утга	82.5	79.9	80.4	78.9	81.6	85,7
Их утга	100	100	96	95.5	98	87
Бага утга	51	32	72.5	48	52	83

Дээрх хүснэгтээс харахад шинжээчдийн эрдэм шинжилгээний өгүүлэлд өгсөн үнэлгээгээр эмийн түүхий эдийн судалгаа дунджаар 82.5 оноо, уламжлалт эмийн судалгаа 79.9 оноо, онол, эх бичгийн судалгаа 81.6 оноо, эмийн онолын судалгаа 80.4 оноо, эмнэлзүйн судалгаа 78.9 оноо авсан байна.

Харин дээрх бүтээлүүдээс уламжлалт эмийн судалгаанд хамгийн доогуур (32 оноо) үнэлгээ авсан судалгаа байсан байна. Эрдэм шинжилгээний бүтээлийн товчлолд өгсөн үнэлгээний дүнг үзүүлэлт тус бүрээр нь авч үзэхэд

Дээрх хүснэгтээс харахад эмийн түүхий эд болон уламжлалт эмийн онолын судалгаа нийт үзүүлэлтэд 80-с дээш хувьтай дүгнэгдсэн байна.

Харин эмийн онолын судалгааны материал, аргазүй 5 оноо (25%), дүгнэлт 12,5 оноо (62,5%), эмнэлзүйн судалгааны үр дүн 7,2 оноо (36,1%), дүгнэлт 10,2 оноо (51.1%) авснаар бусад үзүүлэлтээс доогуур байна.

Эрдэм шинжилгээний өгүүлэлд өгсөн үнэлгээний дүнг үзүүлэлт тус бүрээр нь авч үзэхэд Дээрх хүснэгтээс харахад эмийн түүхий эд болон уламжлалт эмийн судалгаа, онол, эх бичгийн судалгааны аргазүйн хэсэг, тогтолцооны судалгааны ерөнхий бичилт, хэлцэмж, дүгнэлт 90-ээс дээш хувьтай дүгнэгдсэн байна.

Харин хэлцэмжийн үзүүлэлтэд эмийн түүхий эдийн судалгаа 9,2 оноо (61.2%), уламжлалт эмийн судалгаа 9,4 оноо (62,4%), эмнэлзүйн судалгаа 10,3 оноо (68,3%) авснаар бусад үзүүлэлтээс доогуур үнэлгээ авсан, мөн эмийн онолын судалгааны дүгнэлтийн хэсэг 6,7 оноо (66,7%), эмнэлзүйн судалгаа номзүйн үзүүлэлтэд 2,9 оноо (57,5%) авснаар бусад үзүүлэлтээс доогуур байна.

Тогтолцооны судалгааны 3 өгүүлэлд эрдэм шинжилгээний ажлын үүднээс үнэлгээ өгөх боломжгүй гэж дүгнэсэн байна.

ХЭЛЦЭМЖ

- Уламжлалт анагаах ухааны чиглэлээр хийгдсэн судалгааны ажлуудыг 4 веб хуудас, 8 анагаах ухааны сэтгүүлд сүүлийн 10 жилд хэвлэгдэж, нийтлэгдсэн 145 судалгааны ажил байна. Үүнээс эм болон эмийн түүхий эдийн судалгаа (70%) хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд эмнэлзүйн судалгаа (9%) болон тогтолцооны судалгаа (5%) хамгийн бага хувийг эзэлж байна.
- Шинжээч томилон эрдэм шинжилгээний бүтээлүүдэд үнэлгээ хийхэд судалгааны ажлын товчлолын хувьд эмийн түүхий эдийн судалгаа дунджаар 91.6 оноо, харин эмнэлзүйн судалгаа 61.6 оноо авсан байна. Өгүүлэлд өгсөн үнэлгээгээр эмийн түүхий эдийн судалгаа дунджаар 82.5 оноо, харин уламжлалт эмийн судалгаа 79.9 оноо, эмнэлзүйн судалгаа 78.9 оноо авсан байна. Мөн тогтолцооны судалгааны 3 бүтээлд эрдэм шинжилгээний бүтээлийн үүднээс үнэлгээ хийх боломжгүй гэж дүгнэсэн байна.
- Үнэлгээний үзүүлэлт тус бүрээр авч үзэхэд: товчлолд эм болон эмийн түүхий эдийн судалгааны товчлолын материал аргазүй, дүгнэлт гэсэн үзүүлэлтэд 95.2 оноо авсан байна. эмнэлзүйн судалгаа нь бичвэр товч, оновчтой байх (65.2 оноо), судалгааны үр дүнгийн үзүүлэлт (36.1 оноо), дүгнэлт (51.1 оноо) үзүүлэлтүүдэд хамгийн бага үнэлгээ авсан байна.
- Эмийн онолын судалгаа нь материал, аргазүй (25 оноо), дүгнэлт (62.5 оноо), мөн онол, эх бичгийн судалгаа нь материал аргазүйн үзүүлэлтэд хамгийн бага үнэлгээг авсан байна. Эрдэм шинжилгээний өгүүлэлд эм болон эмийн түүхий эдийн судалгааны өгүүлэл нь аргазүйн хэсгийн үзүүлэлтэд 90.7 оноо, харин хэлцэмжийн үзүүлэлтэд 67.5 оноо авсан байна. эмнэлзүйн судалгаа нь ерөнхий бичилт, үр дүнгийн хэсгийн үзүүлэлтэд 85 оноо, харин хэлцэмж 68.3 оноо, дүгнэлт 70 оноо, номзүй 58 оноо авсан байна. онол, эх бичгийн судалгаа нь аргазүйн хэсгийн үзүүлэлтэд 90.6 оноо, харин үр дүнгийн хэсгийн үзүүлэлтэд 74.8 оноо, дүгнэлт 74 оноо, номзүй 76.6 оноо авсан байна.

ДҮГНЭЛТ

Сүүлийн 10 жилд веб болон сэтгүүлд уламжлалт анагаах ухааны чиглэлээр нийтлэгдсэн 145 эрдэм шинжилгээний бүтээл байгаагаас эмнэлзүйн судалгаа (9%) болон тогтолцооны судалгаа (5%) харьцангуй бага хийгдэж байна.

Мөн эксперт томилон эрдэм шинжилгээний бүтээлүүдэд үнэлгээ хийхэд эмнэлзүйн судалгааны товчлол (61.6 оноо), өгүүлэл (78.9 оноо) хамгийн бага оноо авсан нь эмнэлзүйн судалгаа хангалтгүй хийгдэж байгааг харуулж байна.

Харин үнэлгээ хийсэн үзүүлэлтээр нь авч үзэхэд эрдэм шинжилгээний бүтээлүүдийн материал аргазүй, үр дүнгийн хэсэг, хэлцэмж, дүгнэлт нь бусад үзүүлэлтээс доогуур түвшинд бичигдэж байна.